



**БУЛГАН АЙМГИЙН
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2020 оны 11 сарын 10-ны өдөр

Дугаар 8/44

Булган

Г САНХҮҮЖИЛТ ХУВААРИЛАХ ТУХАЙ

Монгол Улсын Засгийн Газрын 2018 оны 400 дугаар тогтоолоор баталсан “Эрчимжсэн мал аж ахуйг дэмжих үндэсний хөтөлбөрийн 4.1.1, 4.7.1, 4.7.3, 4.7.5 дахь заалтууд. Хүнс, Хөдөө, аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2020 оны “Санхүүжилтийн хуваарь батлах тухай” А-352 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрчимжсэн мал аж ахуйг үйл ажиллагааны чиглэлээр нь төрөлжүүлэн ангилах, бүсчлэл тогтоох, шинжлэх ухааны ололтыг үйлдвэрлэлд нэвтрүүлэх, зөвлөх үйлчилгээ үзүүлэх, тусгай хөтөлбөрөөр богино хугацааны сургалт зохион байгуулах хөрөнгийг хавсралтаар баталсугай.
2. Технологийн хугацаанд ажлыг үр дүнтэй зохион байгуулж, ажлын тайланг тогтоосон хугацаанд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлэхийг Мал үржлийн алба /М.Жавзандолгор/-т үүрэг болгосугай.
3. Хавсралтаар баталсан хөрөнгийг хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Ерөнхий санхүүч /Л.Отгон/-т зөвшөөрсүгэй.

ДАРГА Ч.АМГАЛАН